



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2018 оны 09 сарын 12 өдөр

Дугаар А/407

Мандалговь

Г "Хүндэт иргэн" цол, тэмдэгээр
шагнах тухай Г

Монгол Улсын Засгийн газрын 1997 оны 54 дүгээр тогтоол, Сангийн сайдын 2012 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн 239 дүгээр тушаалаар батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2 дугаар зүйлийн 2.3 дахь заалт, аймгийн Засаг даргын 2017 оны А/251 дугаар захирамжаар шинэчлэгдэн батлагдсан "Аймгийн болон Засаг даргын шагнал олгох журам", аймгийн Засаг даргын зөвлөлийн 2018 оны 9 дүгээр сарын 10-ны өдрийн 13 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Сайнцагаан сумын өндөр настан, Монгол Улсын гавьяат багш Зэвэг овогтой Цэвээнравдан, Минжүүрдорж овогтой Содномдорж нарыг аймгийн "Хүндэт иргэн" цол тэмдэг, тус бүр 200000 (Хоёр зуун мянга) төгрөгөөр шагнасугай.

Хоёр. Аймгийн Засаг даргын шагналын дагалдах мөнгөн шагналд 400000 (Дөрвөн зуун мянга), дурсгалын гэрчилгээнд 50000 (Тавин мянга) төгрөгийг тус тус зарцуулсугай.

Гурав. Шагналд зарцуулах 450000 (Дөрвөн зуун тавин мянга) төгрөгийг ЗДТГ-ын орон нутгийн нөөц хөрөнгийн зардлаас гаргаж зарцуулахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Ц.Эрдэнэсүрэн), нягтлан бодогч (Д.Нандинцэцэг) нарт зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



О.БАТ-ЭРДЭНЭ

48801029